

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРААС  
2019 ОНЫ 10 ДУГААР САРД ХЭРЭГЖҮҮЛСЭН  
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2019 оны 10 дугаар сарын 31

Улаанбаатар хот


Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гадаадын иргэн, харьяатын газар нь Төрийн албаны тухай хууль, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Харьяатын тухай хууль болон холбогдох дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон гадаадын болон өөрийн орны иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэхэд анхаарч 2019 оны 10 дугаар сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ. ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

1.1. Виз, зөвшөөрөл, харьяатын чиглэлээр:

Тайлант хугацаанд Монгол Улсад оршин суух үнэмлэх 2110 ширхгийг шинээр хэвлэн, 1912 ширхэг үнэмлэхийн хүчинтэй хугацааг сунгаж, 47 ширхэг үнэмлэхэд хаягийн хөдөлгөөний бичилт хийн, гадаадын гурван иргэнд регистрийн дугаар олгосон байна. Үйлчилгээний танхимаар 1386 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэжээ.

Нийт 3266 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгснөөс 1800-1882 дугаарын утсаар 1592, 7585-1882 дугаарын утсаар 47, биечлэн 624, автомат хариулагчаар 1003 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа. Мөн Тайваны төлөөлөгчийн газар, Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Ханой хот, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хот дахь консулын ажилтанд утсаар виз, бүртгэлийн талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө, долоон улсын гадаадын найман иргэнд цахим шуудангаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан байна.



Цахим визийн зөвшөөрлийн хүрээнд олон улсын хилийн боомт дээр “J” ангиллын 19, “S” ангиллын 104, “B” ангиллын нэг болон хоёр удаагийн орох 64, “B” ангиллын олон удаагийн гарах-орох 133 визийн зөвшөөрөл олгож, нийт давхардсан тоогоор 312 аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийг хүлээн авч хянан, 184 аж ахуйн нэгж, байгууллагын гадаадын 325 иргэний визийн зөвшөөрлийн хүсэлтийг холбогдох хууль, журмын дагуу хянан цахимаар шийдвэрлэжээ.

Үндэсний хөгжлийн газрын дэргэдэх хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн үйлчилгээний төвд тус байгууллагын нэг мэргэжилтэн ажиллаж 95 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгч, гадаадын 50 иргэнд визийн зөвшөөрөл, 64 иргэнд оршин суух зөвшөөрөл олгож, 212 иргэний оршин суух зөвшөөрлийн хугацааг сунган, 16 иргэний ангиллыг сольж, 4 иргэнийг бүртгэж, 41 иргэнд хасалт хийсэн байна. Мөн хөрөнгө оруулагчаар оршин суух зөвшөөрөлтэй 160 иргэнд зохих ангиллын виз олголоо.

2019 оны 10 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад визийн зөвшөөрөл олголт 10.3 хувиар, виз олголт 9.7 хувиар, хувийн урилга олголт 41.2 хувиар, оршин суух зөвшөөрөл олголт 8.4 хувиар, оршин суух зөвшөөрөл сунгалт 0.9 хувиар, оршин суух зөвшөөрлийн хасалт 15.7 хувиар өссөн, харин түр ирэгчийн бүртгэл 6.8 хувиар, түр ирэгчийн хасалт 1.1 хувиар, визийн сунгалт 70.4 хувиар тус тус буурсан байна.


Иргэний харьяалал, олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын чиглэлээр:

Тайлангийн хугацаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дөрвөн удаагийн зарлигаар хоёр улсын зургаан иргэн Монгол Улсын харьяат болж, зургаан удаагийн зарлигаар 87 иргэн Монгол Улсын харьяатаас гарч гадаадын зургаан улсын харьяат болсон ба нэг удаагийн зарлигаар харьяалалгүй хоёр хүний иргэний харьяаллыг сэргээн тогтоосон байна. Дээрх иргэдийн мэдээлэл болон Ерөнхийлөгчийн зарлигийг Гадаад харилцааны яамны Консулын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Монгол Улсаас гадаад улсад суугаа Элчин сайдын яаманд хүргэх ажлыг зохион байгууллаа.

Монгол Улсын харьяатаас гарч гадаадын зургаан улсын харьяат болох хүсэлт гаргасан 22 иргэний хүсэлтийг шинээр хүлээн авч, гадаадын зургаан улсын харьяат болох хүсэлт гаргасан 34 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийсэн. Мөн гадаадын долоон улсын харьяат болох хүсэлт гаргасан 66 иргэний хүсэлтэд холбогдох байгууллагаас санал авч дүгнэлт гарган Ерөнхий сайдад танилцуулахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт, долоон улсын харьяат болох хүсэлт гаргасан 50 иргэний хүсэлтийг Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчийн Тамгын газарт тус тус хүргүүлэв.

Монгол Улсын иргэний харьяаллаа сэргээн тогтоолгох хүсэлт гаргасан харьяалалгүй нэг хүний хүсэлтийг шинээр хүлээн авч, холбогдох байгууллагаас санал авах ажиллагааг хийж байна.

Мөн хоёрдмол харьяалал үүсгэсэн 54 иргэнийг шинээр бүртгэж мэдээллийн санд оруулсан ба нийт 3484 иргэн бүртгэлтэй байна.



Мэргэжлийн зөвлөлийн хурлаар олон улсын болон гадаад улсын 13 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын асуудлыг хэлэлцэн найман төрийн бус байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгаж, таван байгууллагын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон байна. Түүнчлэн дээрх хугацаанд үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах хүсэлт гаргасан долоон төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын хүсэлтийг хүлээн авсан. 2019 оны 10 дугаар сарын байдлаар тус байгууллагад бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж буй 89 төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газар байна.

Монгол Улсын харьяат хүүхэд үрчлэн авах хүсэлт гаргасан гадаад улсын нэг гэр бүлтэй байгууллагын даргын 2010 оны А/395 дугаар тушаалаар баталсан “Монгол Улсын харьяат хүүхдийг үрчлэх хүсэлт гаргасан гадаадын иргэнтэй ярилцлага хийх журам”-ын дагуу ярилцлага хийн, Мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлснээр Монгол Улсын харьяат нэг хүүхдийг үрчлүүлж, үрчлэгч тал, төрийн бус байгууллагын төлөөлөгч нартай үрчлэлтийн дараах хяналт тавих гурван талт гэрээг байгуулсан.


#### 1.2. Хяналт шалгалт, албадан гаргах ажиллагааны чиглэлээр:

Тайлант хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг үндэслэн зургаан улсын 210 иргэнийг байгууллагын даргын 16 удаагийн тушаалаар тус улсаас албадан гаргасан ба мэдээллийг холбогдох газруудад албан бичгээр хүргүүлэх ажлыг зохион байгуулав.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасан үндэслэлээр байгууллагын даргын зургаан удаагийн тушаалаар гадаадын дөрвөн улсын зургаан иргэнийг Монгол Улсаас гарахыг түдгэлзүүлж, нэг удаагийн тушаалаар гадаадын нэг иргэний хилээр нэвтрэх эрхийг сэргээн ажиллалаа.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зааснаар 326 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн ба Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд заасан үндэслэлээр хоёр улсын 10 иргэнд гарах сануулга өгч, Хан-Уул дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүгчийн 11 захирамжаар гадаадын нэг улсын 11 иргэнийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа Баривчлах төвийн байранд саатуулсан.

Тайлант хугацаанд 14 удаагийн төлөвлөгөөт, 23 удаагийн төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 336 аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын 5001 иргэнийг хамруулсан ба 286 гадаадын иргэн, 221 аж ахуйн нэгж, байгууллага /гадаадын 735 иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулж, 1,200,340,000 /нэг тэрбум хоёр зуун сая гурван зуун дөчин мянга/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүллээ.



2019 оны 10 дугаар сарын дээрх тоон үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад зөрчил гаргасан уригч хуулийн этгээд 36.4 хувиар, албадан гаргагдсан гадаадын иргэн 2.4 дахин өссөн, харин зөрчил гаргасан гадаадын иргэн 4.7 хувиар буурсан байна.

## ХОЁР. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР

2.1. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт, дотоод ажил, хүний нөөц, сургалт, олон нийттэй харилцах чиглэлээр:

“Хил хяналтын байгууллагын ажлын уялдаа холбоог хангах тухай”, “Хилийн боомтыг шилжүүлэх тухай”, “Агаарын замын боомтын асуудлаар авах арга хэмжээний тухай” Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн зөвлөмж, тогтоолын хэрэгжилт, байгууллагын дэргэдэх хүүхдийн цэцэрлэг байгуулсан тухай товч танилцуулгыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад, “Ахмад настан-хэрэглэгч” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хүрээнд тус байгууллагаас хэрэгжүүлсэн ажлын тайлан, тус байгууллагын хэмжээнд 2020-2024 онд авч хэрэгжүүлэх бодлого, бүтээн байгуулалтын төсөл, арга хэмжээний талаарх саналыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргад, байгууллагын 2019 оны 09 дүгээр сарын үйл ажиллагааны тоон мэдээг инфографик хэлбэрээр гарган Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргад, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны 05 дугаар зарлигаар баталсан “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээллээр хангах журам”-ын дагуу тус байгууллагад холбогдох хэсгийн хэрэгжилт, байгууллагын 2019 оны 09 дүгээр сарын үйл ажиллагааны тайланг Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргад, байгууллагын “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны 2019 оны төлөвлөгөө”-ний гуравдугаар улирлын тайланг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албанд тус тус хүргүүлэн ажиллалаа.

Байгууллагын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Дорнод аймгийн Зүүн бүс дэх газарт мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, шалган зааварлах ажлыг зохион байгуулсан.

Төв болон орон нутаг дахь газарт нийт 80 өргөдөл, хоёр гомдол ирснийг хүлээн авч, бүртгэлжүүлэн харьяалах газар, хэлтэст нь шилжүүлснээс 63 өргөдөл, хоёр гомдол шийдвэрлэгдэж, 17 өргөдөл хуульд заасан хугацааны хүрээнд шийдвэрлэлтийн шатандаа байгаа ба хугацаа хэтэрсэн өргөдөл байхгүй.

Сул орон тооны сонгон шалгаруулалтын захилгыг Төрийн албаны зөвлөлд албан бичгээр хүргүүлснээр Гадаадын иргэн, харьяатын газрын гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын зар Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд байршуулж, бүртгэлийг байгууллагын төв байранд хийснээр, сонгон шалгаруулалтыг хийх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албаны шинэтгэл, сэтгүүлчдийн оролцоо” сэдэвт сургалт, Удирдлагын академийн Төрийн албаны сургуулиас зохион байгуулж буй Эрхэлсэн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд ажиллаж буй албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалт, Тайвань Улсын Үндэсний цагаачлалын агентлагийн санаачлагчаар зохион байгуулагдсан “Хилийн боомтын менежмент-2019” сургалт семинарт тус тус холбогдох албан хаагчдыг хамрууллаа.

Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 2019 оны эхний 10 сарын тоон мэдээллийг сэтгүүлчдэд танилцуулж, цаг үеийн асуудлаар тайлбар мэдээлэл хийсэн хэвлэлийн бага хурлыг 10 дугаар сарын 17-ны өдрийн 11 цагт Нийслэлийн хэвлэл мэдээллийн төвд зохион байгууллаа. Хэвлэлийн хуралд 18 телевиз, 14 цахим хуудас, долоон сонин, нийт 29 байгууллагын 50 орчим сэтгүүлч, сурвалжлагчид хүрэлцэн ирж, мэдээ, ярилцлага, сурвалжилга бэлтгэн олон нийтэд хүргэв. Хэвлэлийн хурлын үеэр байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тоон мэдээллийг нэгтгэсэн гарын авлага, хяналт шалгалт хийж буй 13 минутын дүрс бичлэг хувилсан DVD-г сэтгүүлчдэд хүргүүлэв. Мөн “Монголын үндэсний олон нийтийн телевиз”, “UBS” телевизийн “Зочны цаг”-т байгууллагын дарга оролцож, цаг үеийн асуудлаар мэдээлэл, “SBN” телевизийн “Бодит тайлбар” нэвтрүүлэгт хяналтын улсын ахлах байцаагч оролцож гадаадын иргэдийн хяналттай холбоотой нийгмийн сүлжээнд тавигдсан мэдээллүүдэд бодит тайлбар өглөө. Дээрх хэвлэлийн хурал, нэвтрүүлэг, бусад мэдээ мэдээллийг тухай бүр байгууллагын болон мэдээллийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажилласан.

## 2.2. Хууль, эрх зүй, гадаад харилцааны чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд өгөх байгууллагын саналыг Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлж, мөн Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг дагаж гарах Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулахад шаардагдах тооцоо, судалгааг хийхэд шаардлагатай лавлагаа авахаар Гадаад харилцааны яамны төрийн нарийн бичгийн даргад албан бичгээр хандсан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны “Жагсаалт батлах тухай” А/70 дугаар тушаалд өөрчлөлт оруулах саналыг тус байгууллагаас Хууль зүй, дотоод хэргийн яаманд гаргаж, сайдын тушаалын төсөл, тушаал гаргахад шаардагдах нэмэлт тайлбарыг Хууль зүй, дотоод хэргийн мэргэжилтэнд цахим шуудангаар хүргүүллээ.

Байгууллагын төв болон орон нутаг дахь газрын нийт зургаан албан хаагч Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах орны Хөх хотноо

10 дугаар сарын 21-ээс 11 дүгээр сарын 04-ний хооронд зохион байгуулагдаж буй “2019 оны хил хамгаалах болон хилээр орох-гарах асуудал хариуцсан ажилчдын сургалт”-д уригч талын зардлаар хамрагдаж байна.

Байгууллагын дарга тэргүүтэй төлөөлөгчид Америкийн Нэгдсэн Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамны консулын Хэлтсийн шинээр томилогдсон дарга Брайн К.Вингейтийг байгууллага дээрээ хүлээн авч уулзан цаашдын хамтын ажиллагааны талаар, мөн байгууллагын даргын урилгын дагуу Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Нийгмийг аюулаас хамгаалах тэнхимийн орлогч дарга Лиан Линниань тэргүүтэй таван төлөөлөгчид Гадаадын иргэн, харьяатын газарт 10 дугаар сарын 07-оос 11-ний өдрийн хооронд албан айлчлал хийж хамтын ажиллагааны талаар тус тус санал солилцов.

### 2.3. Мэдээллийн технологийн чиглэлээр:

Үндэсний дата төв, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран Операторын үйлчилгээнд холбогдох есөн төрлийн лавлагааг Төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системээр дамжуулан холбох сервисийг бэлтгэн Үндэсний дата төвийн холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгөв. Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран Монгол Улсад ирж байгаа гадаадын иргэдийн бүртгэлийг зочид буудлуудад бүртгэх бэлтгэл ажлын хүрээнд албан уулзалтыг зохион байгуулж, “ХУР” системд холбох гадаадын иргэний бүртгэлийн сервисийг бэлтгэн системийн мэргэжилтэнд цахим шуудангаар хүргүүлээ.

### 2.4. Санхүү, хөрөнгө оруулалт, хангамжийн чиглэлээр:

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын багцад Монгол Улсын Төсвийн тухай хуулийн дагуу 2019 онд 6,27 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд өссөн дүнгээр 10 дугаар сард 5,34 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсоноос 4,64 тэрбум төгрөгийг зохих дүрэм, журмын дагуу анхан шатны баримтыг үндэслэн зарцуулсан.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Засгийн газрын 2003 оны 172 дугаар тогтоолын дагуу 10 дугаар сарын байдлаар 4 тэрбум 750 сая төгрөгийн тэмдэгтийн хураамжийн орлого, 1 тэрбум 516 сая төгрөгийн хүү торгуулийн орлого, 74,9 сая төгрөгийн визийн хуудасны орлогыг улсын төсөвт төвлөрүүлээ.

### 2.5. Хяналт шинжилгээ, аудитын чиглэлээр:

Байгууллагын үндсэн үйл ажиллагааны 2019 оны 09 дүгээр сарын мэдээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Ерөнхий сайдын ажлын албанд, мөн сарын статистик мэдээг Хууль зүй, дотоод хэргийн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газарт, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар төлөөлөгчийн газрын 2019 оны гуравдугаар улирлын мэдээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албанд тус тус хүргүүлсэн.

2019 оны байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээ хийлгэхтэй холбогдуулан техникийн тодорхойлолтыг боловсруулж үнэлгээний хороонд хүргүүлээ.

Байгууллагын даргын баталсан удирдамжийн дагуу Дорнод аймгийн Зүүн бүс дэх газарт төлөвлөгөөт, Ховд аймгийн Баруун бүс дэх газарт төлөвлөгөөт бус дотоод аудитын хяналт шалгалтыг зохион байгуулж ажиллав.

## 2.6. Хилийн боомт, орон нутгийн чиглэлээр:

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд заасны дагуу гадаадын 479 иргэнийг орох чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан ба зохих бичиг баримтын бүрдэл хангаагүй гадаадын 15 иргэнийг гарах чиглэлд хил нэвтрүүлэлгүй буцаасан.

Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, консулын газар, өргөмжит консулаас визийн хүчинтэй хугацаа, нэр, огноо буруу, визийн зориулалт бичигдээгүй зэрэг гадаадын 27 иргэнд олгогдсон визийг тухай бүр хуулбарлан авч, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолын дагуу визийг дахин олгон хил нэвтрүүлсэн болно.

Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн газар, Монгол Улсын өргөмжит консулын газраас алдаатай олгосон болон засвартай визийн мэдээллийг хилийн боомт, орон нутгаас авч нэгтгэн нийт 63 орны 708 гадаадын иргэнд визийн алдаатай, Монгол Улсаас албадан гаргасан иргэдэд орохыг үл зөвшөөрсөн хугацаанд виз олгохгүй байх үүргийг зөрчиж олгосон дөрвөн зөрчлийг нэгтгэн Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн даргад албан бичгээр хүргүүллээ.

Увс аймгийн “Дэглий цагаан” нисэх буудалд шинээр боомт байгуулж, олон улсын нисэх буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулахад манай байгууллагад шаардагдах бүтэц орон тоо, гарах зардлын тооцооллыг Иргэний нисэхийн ерөнхий газрын тэргүүн дэд даргад, Бичигт олон улсын авто замын боомтын шинээр баригдах шалган нэвтрүүлэх цогцолборт тус байгууллагаас ажиллах албан хаагчдын тоон мэдээллийг “Татах хүч” ХХК-д тус тус албан бичгээр хүргүүлсэн.

Үйл ажиллагаа явуулж буй хилийн 14 боомтод ажлын өдрийн 09:00, 16:00 цагуудад хил нэвтрэлт, онцлог нөхцөл, удирдлагын үүрэг, даалгаврыг нийт 25 удаа авч, бүртгэлийн дэвтэрт хөтлөн ажиллалаа. Түүнчлэн байгууллагын даргын 2019 оны 08 дугаар албан даалгавар гарсантай холбогдуулан орон нутаг дахь газруудаас гадаад иргэдийн хил нэвтрэлт, хил дээрээс буцаасан тоон мэдээг өдөр бүр нэгтгэж удирдлагад танилцуулан ажиллаж байна.

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗАР